

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН
АЛБАН ХААГЧДЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ 2019 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2019 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Багануур дүүрэг

№	АЛБАН ХААГЧИЙН НЭР	АЛБАН ТУШААЛЫН НЭР	СУРГАЛТЫН НЭР	ХЭРЭГЖИЛТ	ГҮЙЦЭТГЭЛ ХУВЬ
1	Б.Мичид-Эрдэнэ	Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн	Худалдан авах ажиллагааны АЗ	2019 оны 04 дүгээр сард “Худалдан авах ажиллагааны АЗ” сертификат олгох сургалтад хамрагдав.	100%
2	Б.Мичид-Эрдэнэ	Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн	ШУТИС-ийн БАТС-ийн Логистикийн менежментийн магистрын хөтөлбөр	“Логистикийн менежмент”-ийн магистрын хөтөлбөрт суралцаж, “Үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагааг эрчимжүүлэх боломж” сэдвээр магистрын зэрэг хамгаалахаар бэлтгэж байна.	100%
3	М.Мөнхдулам	Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн	Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэшүүлэх сургалт	2019.04 сард Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын даргын тушаалаар Монголын Хүний Нөөцийн Удирдлага Шинэчлэлийн Академийн “Оффис менежер, архив, бичиг хэргийн ажилтны сургалт”-д хамрагдаж Сертификат авсан.	100%
4	Д.Оюунсүрэн	Хөрөнгө оруулалт, олон нийттэй харилцах харилцаа хариуцсан мэргэжилтэн	Худалдан авах ажиллагааны АЗ	Худалдан авах ажиллагааны АЗ” сертификат олгох сургалтад хамрагдав.	100%

5	С.Отгонбаатар	Хуулийн зөвлөх	Худалдан авах ажиллагааны АЗ	Худалдан авах ажиллагааны АЗ” сертификат олгох сургалтад хамрагдав.	100%
6	Д.Алтангэрэл	Үйлдвэрлэл, технологийн албаны Ахлах мэргэжилтэн	Төслийн удирдлага	Герман улсын “GIZ” хөтөлбөрөөс зохион байгуулсан инновацийн төсөл боловсруулах сургалтад хамрагдав.	100%
7	Б.Мөнгөнхуяг	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, дэд бүтцийн инженер	Норм нормативын баримт бичиг болон дүрэм журмуудын тухай	Мэргэшсэн инженерийн багц сургалтыг нэг болох “Норм нормативын баримт бичиг болон дүрэм журмуудын тухай” сургалтад 2019 оны 02 дугаар сард хамрагдсан.	100%
8	Б.Мөнгөнхуяг	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, дэд бүтцийн инженер	CIVIL 3D	CIVIL 3D болон 3D Max программуудыг бие даан эзэмшиж, паркийн бүсүүдийн төлөвлөлт, зургийн даалгавар, газар зохион байгуулалт зэргийг төлөвлөж, зураглалыг боловсруулсан.	30%
9	Б.Мөнгөнхуяг	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, дэд бүтцийн инженер	Autocad, 3D Max хосолсон сургалт		30%
10	Ч.Баярцэцэг	Программ хангамж, бүртгэл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн	Веб дизайнер, программ хөгжүүлэлт	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлтийг тогтмол хийж, баяжуулан ажилласан. - In design болон photoshop программуудыг бие даан суралцаж Паркийн танилцуулга, брошурыг мэргэжлийн түвшинд бэлтгэж сурсан. 	30%
Паркаас зохион байгуулсан сургалт, зөвлөгөөний биелэлт					

1	2019 онд албан хэрэг хөтлөлт, архивын ажлын үндсэн зааврын тухай сургалтыг 4 удаа зохион байгуулж, албан хаагч нарыг Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэсэн.	100%
2	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем дэд системүүдийн сургалтыг дотооддоо улирал бүр зохион байгуулж, программ ашиглалтыг жигдрүүлсэн.	100%
3	<p>Хуулийн зөвлөх Отгонбаатар нь паркийн нийт албан хаагч нарт сар бүр нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд болон үйлдвэрлэл, технологийн паркад ашиглагддаг хууль эрх зүйн актуудыг тайлбарлан хүргэх сургалтуудыг зохион байгуулж ажиллаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаатай холбогдох татварын багц хуулиуд - Олон улсын Үйлдвэрлэл, технологийн паркуудын хууль эрх зүйн бодлого - Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай - Шинээр гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүд - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад ашиглагддаг нийтлэг журмуудын тухай - Хүнд үйлдвэрийг дэмжих тухай хууль - Хөрөнгө оруулалтын тухай хууль болон хөрөнгө оруулалтын гэрээний хавсралтуудыг бэлтгэх тухай - Паркийн даргын тушаалын хууль эрх зүйн үндэслэлд хамаарагдах хуулиуд - Байгууллагын орон тооны бус салбар зөвлөлүүдийн тухай - Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт - Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулиудын тайлбар - Үндэсний хөтөлбөрүүд болон дэд хөтөлбөрүүдийн тухай 	100%
4	Программ хангамж, бүртгэл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн болон Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн нар хамтран байгууллагын нийт албан хаагч нарт "Filezila төв сервер болон цахим архивын ач холбогдол" сэдвээр сургалт явуулж, албан хаагч нарын компьютерын файлуудыг ХХНЖ-ын дагуу цэгцлэх ажлыг зохион байгуулав.	100%
5	2019.03.22 болон 2019.06.21-ний өдрүүдэд БҮТП-д Биотехнологийг хөгжүүлэх нь уриан дор "Ховор эмийн ургамал, жимс жимсгэнэ тариалах нь" сэдэвт V, VI сургалт зөвлөгөөнийг дүүргийн үйлдвэр, аж ахуйн нэгж, иргэдийг оролцуулан 2 удаа амжилттай зохион байгуулж, Хөх нуурын био станц, Хэрлэн баян улааны ховор эмийн ургамлын плантацитай	100%

	танилцаж туршлага судлав. Тус арга хэмжээнд ХААИС, ШАУИС, УХЭШХ болон ШУУ-ийн Монхимо ХХК-иудын төлөөллүүд эрдэм шинжилгээ, судалгааны ажлаар илтгэл тавьж оролцсон.	
6	Паркийн санаачилгаар “Нийслэлийн паркуудын тулгамдсан асуудал ба инновацийг хөгжүүлэх арга зам” сэдэвт уулзалт зөвлөгөөнийг НШУҮИГ-т зохион байгуулж, өөрийн паркийн тулгамдаж буй асуудал болон БҮТП-д инновацийг хөгжүүлэх нь гэсэн 2 сэдвээр илтгэл тавьж, санал зөвлөмжүүдийг сонслоо.	100%
7	Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан”-г дүүргийн 5 хорооны иргэд болон Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авахаар 2019.12.04-ний өдөр хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт 5 хорооноос нийт 82 иргэн хамрагдаж, 6 хүн санал асуулга тавьж, 25 иргэн бичгээр саналаа өгсөн. Паркийн зүгээс 5 хорооны ИНХ-ын даргад олон нийтийн нэгдсэн дүн, хэлэлцүүлэгтэй холбогдох материалыг хүргүүлж дүүргийн хороодын Иргэдийн нийтийн хурлаас дэмжиж буй тогтоол, саналыг авч Санни трейд ХХК-д хүргүүлэв. Тус ажил нь албан хаагч нарт арга хэмжээ удирдан зохион байгуулах туршлага болсон.	100%
Нийслэл, дүүргээс зохион байгуулсан сургалтад оролцсон байдал		
1	Хүний нөөцийн удирдлага шинэчлэлийн академийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан бэлтгэх 1 сарын сургалтад мэргэжилтэн Ш.Ууганбаяр хамрагдаж Сертификат авсан.	100%
2	2019.03.06-ны өдөр Нийслэлийн архивын газар болон Багануур дүүрэг хамтран “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа болон E-doc системийн ашиглалт хэрэглээг сайжруулах нь” сэдэвт сургалтад Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн Мөнхдуламыг хамруулсан.	100%
3	2019.04.03-нд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын чадавх бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан “Илтгэх ур чадварын үндэс болон UB ERP дотоод удирдлагын системийн хэрэглээ” гэсэн 2 сургалтад Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн М.Мөнхдулам, Ахлах мэргэжилтэн Б.Мичид-Эрдэнэ нар хамрагдсан	100%
4	2019.04.04-05-ны өдрүүдэд Инновацийн сангаас зохион байгуулсан төслийн сургалтад Ахлах мэргэжилтэн Д.Алтангэрэл хамрагдсан. Тус сургалтын төслийн эдийн засгийн нарийвчилсан тооцоо боловсруулах аргыг Үйлдвэрлэл, технологийн албаны инженер, мэргэжилтнүүдэд зааж сургаж.	100%

5	2019.05.02-нд “UB ERP – Өргөдөл, гомдол цэсийн үйл ажиллагааг сайжруулах тухай” дүүргээс зохион байгуулсан сургалтад Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн М.Мөнхдулам, Ахлах мэргэжилтэн Б.Мичид-Эрдэнэ нар хамрагдаж паркийн албан хаагч нарт зааварчилгаа өгөв.	100%
6	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаа, албан хаагчдыг хариуцлагажуулах ажлын хүрээнд “Байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналтын карт нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтыг 2019.06.12-нд зохион байгуулсан тул Ахлах мэргэжилтэн Б.Мичид-Эрдэнэ болон Программ хангамж, бүртгэл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн Ч.Баярцэцэг нар хамрагдаж, 2019.06.13-нд нийт албан хаагч нарт сургалтын мэдээллийг танилцуулав.	100%
7	2019.06.18-нд Нийслэлийн архивын газраас зохион байгуулсан улсын үзлэгийн бэлтгэл, зохион байгуулалтыг хангуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтад Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн М.Мөнхдулам, Ахлах мэргэжилтэн Б.Мичид-Эрдэнэ, Программ хангамж, бүртгэл, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн Ч.Баярцэцэг нар хамрагдсан. Тус сургалтын дагуу БҮТП-ийн даргын тушаалаар улсын үзлэгт бэлтгэх байгууллагын салбар комиссыг байгуулан ажлыг эрчимжүүлсэн.	100%
8	УУХҮЯ, МИНИС төсөл болон GREENTRENDS-ийн хамтран зохион байгуулсан “Нүүрснээс нийлэг байгалийн хий гарган авах үйлдвэр байгуулах төслийн бүс нутгийн байгаль орчны үнэлгээний тайлангийн төсөл”-ийн олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэгт хамт олноороо оролцож, саналаа дэвшүүлсэн.	100%
9	УХЗАА болон ЭМНБХ-гээс зохион байгуулсан “Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвшье” сэдэвт сургалтад Үйлдвэрлэл, технологийн албаны инженер, мэргэжилтнүүд хамрагдаж, сургалтаас авсан шинэ санаагаа байгууллагын албан хаагч нарт танилцуулж, улмаар үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар эрдэст компост бордоо хийх ажилд ашиглав.	100%
10	Монголын мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүдийн холбооны гүйцэтгэх захирал С.Даваанямын “Аюулгүй байдал байгууллагын соёл” сэдэвт сургалтад 2019.04.23-ны өдөр Ахлах мэргэжилтэн Б.Мичид-Эрдэнэ хамрагдаж сургалтын мэдээлэл болон “MOSHPA” холбооны талаар хамт олонд танилцуулсан.	100%
11	Тагнуулын ерөнхий газрын Нийслэл дэх газраас зохион байгуулсан Гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх сургалтад 2019.05.23-ны өдөр 5 албан хаагч оролцож, мэдээлэл авав.	100%

12	2019.06.18-нд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зохион байгуулсан “Үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэл”-ээр удирдах албан тушаалтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтад паркийн дарга, Маркетинг, олон нийтийн харилцаа, хот хариуцсан мэргэжилтэн нар хамрагдаж, хамт олны хурал дээр танилцуулав.	100%
13	Багануур дүүргээс Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан Авлигийн тухай сургалтад 2019.06.27-нд хамт олноороо оролцож, мэдээлэл авав.	100%
14	2019.09.07-ны өдөр Багануур дүүргээс Улсын үзлэг шалгалтын бэлтгэл ажлыг хангах 4 чиглэлээр зохион байгуулсан сургалтад байгууллагын улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангах комиссын бүрэлдэхүүн хамрагдав.	100%
15	2019.10.23-нд дүүргийн ЗДТГ-ын ТЗУХ-ээс зохион байгуулсан Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, тайлагнах арга зүйн сургалтад паркийн нийт албан хаагч нар хамрагдаж, байгууллагын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж эхэлсэн.	100%
16	Нийслэл дэх Төрийн аудитын газар, Монголын Үндэсний Дотоод Аудиторуудын холбоо ТББ-тай хамтран зохион байгуулсан “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, аудит, хяналт шалгалтаар илэрсэн нийтлэг зөрчил”-ийн тухай сургалтад паркийн дарга, нягтлан бодогч нар 2019.11.29-нд хамрагдав.	100%
17	Багануур дүүргийн ЗДТГ-аас 2019.11.16-нд Бүгд Найрамдах Улс тунхагласан өдрийг угтан төрийн албан хаагчдыг чадавхжуулах, хөгжүүлэх зорилгоор “Имако консалтинг институт”-тай хамтран зохион байгуулсан “ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙ, ХАРИЛЦАА ХАНДЛАГА, БАГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА” сэдэвт сургалтад Ахлах мэргэжилтэн Б.Мичид-Эрдэнэ хамрагдаж, байгууллагын албан хаагч нарт сургалтын мэдээллийг танилцуулж, кейс материалыг ашиглан сургалт хийв.	100%
18	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс санаачлан дүүргийн салбар зөвлөл болон Монголын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэшсэн холбоотой хамтран дүүргийн иргэд, аж ахуй нэгж байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнуудыг чадавхжуулах” сэдэвт сургалтыг 2019.11.15-нд зохион байгуулсан. Тус сургалтад Үйлдвэрлэл, технологийн албаны 3 инженер хамрагдаж Сертификат авсан.	100%
19	“Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ы хүрээнд дараах сургалтуудад хамрагдав. Үүнд: - 2019.12.02-нд дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтсээс “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ы хүрээнд “Ойлгоё хүндэлье – Гэр бүлийнхээ төлөө” уриан доор зохион байгуулж буй уулзалтад Үйлдвэрлэл, технологийн кластер инженер оролцож, тус аянд нэгдэв.	100%

	<ul style="list-style-type: none"> - Мөн 2019.12.06-ны өдөр Багануур дүүрэг дэх Цагдаагийн хэлтсээс зохион байгуулсан “Гэр бүлийнхээ төлөө” сэдэвт хэлэлцүүлэгт Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, дэд бүтцийн инженер оролцож саналаа хүргэв - Нийслэлийн ЗДТГ-аас зохион байгуулж буй “Жендэр ба хөгжил” нийслэлийн анхдугаар чуулганд паркийн дарга болон Маркетинг, олон нийтийн харилцаа, хот хариуцсан мэргэжилтэн нар 2019.12.09-ний өдөр оролцов. - Аяны хүрээнд байгууллагын албан хаагч нарт мэдээллийг хүргэж, цахим хуудсанд “Ойлгоё хүндэлье – Гэр бүлийнхээ төлөө” уриалгыг байршуулж, мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулав. 	
ДУНДАЖ ХУВЬ		94,2%

ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.МИЧИД-ЭРДЭНЭ